

CRYPTO WEEK

powered by  ardcoin



Ард Даатгал ХК

MSE: AIC

Хувьцаа Эзэмшигчдийн Хурал

ХУРЛЫН ИРЦ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

CRYPTO WEEK

powered by  **ardcoin**

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

“АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №1

2024 оны 4 сарын 23-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
хурлын хүчин төгөлдөр тооцох тухай

Компанийн нэр: Ард Даатгал ХК

Компанийн хаяг: Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 сарын 23-ны өдрийн 10:00 цагт Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сэнтрал Тауэрын 17 давхар, Ард Апп

Бүртгэлийн өдөр: 2024 оны 03 сарын 31-ний өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2024 оны 04 сарын 19-ний өдрийн 10:00 цаг хүртэл

Тооллогын комисс: Ө.Бямбагэрэл, Т.Батбаяр, Д.Бямбажаргал

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ:

- Саналын эрхтэй 25,000,000 ширхэг энгийн хувьцаанаас ... ширхэг буюу ... хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.
- Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

ХУРЛЫН ДЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

10:00

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх

- ▲ Хурлын ирц танилцуулах (Тооллогын комисс)
- ▲ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах

10:20

Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх

- ▲ Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
- ▲ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
- ▲ Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
- ▲ ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;

11:00

Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт

11:10

Санал хураалт

11:20

Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах


11:30

Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах


ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 1

**2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

CRYPTO WEEK

powered by  **ardcoin**

КОМПАНИЙН БҮТЭЦ



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



2022 оны санхүүгийн
тайланг **АУДИТААР**
баталгаажуулав



МХБ-ийн **ТОП 20**
индекс



Хувь тэнцүүлсэн
урамшуулал
АРДКОЙН олгосон

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ICT EXPO '23



Хувьцаа эзэмшигчдийн хурал АМЖИЛТТАЙ зохион байгуулав



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН ЧУУЛГАН '23

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



MSH CHINA санамж
бичиг байгууллаа




МҮХАҮТ-ийн Удирдах
зөвлөлд сонгогдон
ажиллаж байна.



IPO 5 жил
2018-2023

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ARD | ДААТГАЛ
SINCE 1994

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН
АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ**
Хэрхэн даатгуулах вэ?

**АРД
АППААР**

info@arddaatgal.mn
7720 0088

Ард Аппаар даатгуулах ▶

QR code

Жолоочийн
хариуцлагын албан
журмын даатгал **ARD**
APP-д



ARD | ДААТГАЛ
SINCE 1994

**Гадаад аяллын
даатгалын хамгаалалтууд**

Ковид-19
Эрүүл мэнд, гэнэтийн осол
Ачаа тээвэр саатах
Нислэг хойшлогдох, цуцлагдах

info@arddaatgal.mn
7720 0088

Ард Аппаар даатгуулах ▶

QR code

КОВИД-19
хамгаалалт Гадаад
аяллын даатгалд



ARD | ДААТГАЛ
SINCE 1994

**1
МИНУТ**

Даатгалын нөхөн төлбөрийн материал илгээхэд
АМАРХАН БОЛЛОО

ARD

QR code


Google Play
App Store

Хүчтэй. Хамтдаа.


Нөхөн төлбөрийн
материал хүлээн авах
процессыг
ЦАХИМЖУУЛЛАА.

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ


Нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгө
сая төгрөг



Нөөц сан
сая төгрөг




Хураамжийн орлого
сая төгрөг



■ Нийт хураамжийн орлого
■ Цэвэр хураамжийн орлого

Нөхөн төлбөр
сая төгрөг





■ Нийт нөхөн төлбөр ■ Цэвэр нөхөн төлбөр

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Хөрөнгө оруулалтын багц
сая төгрөг

Цэвэр ашиг
сая төгрөг



ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

№	Даатгалын хэлбэр	2021	2022	2023	YOY
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	3,475	4,395	5,217	18.7%
2	Хөрөнгийн даатгал	3,594	4,212	5,557	31.9%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,842	4,115	6,982	69.7%
4	Ачааны даатгал	291	265	348	31.3%
5	Барилга угсралтын даатгал	1,143	2,988	552	-81.5%
6	Газар тариалангийн даатгал	-	-	-	
7	Мал амьтдын даатгал	149	249	217	-12.7%
8	Агаарын хөлгийн даатгал	-	8	-	0.0x
9	Авто ТХ-ийн жолоочийн хариуцлагын даатгал	7	20	29	47.1%
10	Хариуцлагын даатгал	1,449	1,540	2,064	34.1%
11	Санхүүгийн даатгал	99	188	426	2.3x
12	Зээлийн даатгал	640	972	3,089	3.2x
13	Итгэлцлийн даатгал	-	-	-	
14	Агаарын хөлгийн хариуцлагын даатгал	-	-	-	
15	Жолоочийн хариуцлагын даатгал	2,774	3,363	7,957	2.4x
НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ДҮН		16,462	22,316	32,438	45.4%

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

№	Даатгалын хэлбэр	2021	2022	2023	YOY
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	963	1,760	2,197	24.9%
2	Хөрөнгийн даатгал	278	121	1,103	9.1x
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,017	1,301	2,608	2.0x
4	Ачааны даатгал	407	96	36	-62.4%
5	Барилга угсралтын даатгал	24	354	-	0.0x
6	Газар тариалангийн даатгал	72	-	-	
7	Мал амьтдын даатгал	139	-	449	
8	Агаарын хөлгийн даатгал	-	-	-	
9	Авто ТХ-ийн жолоочийн хариуцлагын даатгал	-	-	-	
10	Хариуцлагын даатгал	318	76	80	5.6%
11	Санхүүгийн даатгал	-	-	1,706	
12	Зээлийн даатгал	551	1,617	1,759	8.8%
13	Итгэлцлийн даатгал	-	-	-	
14	Агаарын хөлгийн хариуцлагын даатгал	-	-	-	
15	Жолоочийн хариуцлагын даатгал	1,197	2,533	4,157	64.1%
НИЙТ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ДҮН		4,967	7,859	14,095	79.4%

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ

ХАРЬЦАА /хувиар/	2021	2022	2023
Хохирлын харьцаа ЦНТ/ОТХ	35.5	40.2	41.4
Зардлын харьцаа ҮАЗ/ОТХ	70.8	59.6	55.6
Хосолсон харьцаа LR+ER (ОТХ)	106.2	99.8	97.0
Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт (110%-с дээш) *2023 онд эрсдэлд суурилсан хөрөнгөд үндэслэн тооцоолдог болсон	115.8	118.0	*242.0
ROA Нийт хөрөнгийн өгөөж	36.8	2.3	8.2
ROE Өөрийн хөрөнгийн өгөөж	73.8	4.6	18.6

ОРЛОГЫН ТАЙЛАН

(сая төгрөг)	2021	2022	2023	YOY
Нийт хураамжийн орлого	16,462	22,316	32,438	45%
Давхар даатгал	(2,399)	(4,231)	(5,660)	34%
Буцаасан даатгал	(570)	(469)	(828)	77%
Цэвэр хураамжийн орлого	13,493	17,616	25,950	47%
Орлогод тооцсон хураамж	11,693	15,016	20,147	34%
Нийт нөхөн төлбөр	(4,967)	(7,859)	(14,095)	79%
Давхар даатгалаас	336	255	3,804	15x
Буруутай этгээдээс	482	1,574	1,951	24%
Цэвэр нөхөн төлбөр	(4,149)	(6,030)	(8,341)	38%
Хөрөнгө оруулалтын олз/гарз	9,295	436	3,145	7x
Үйл ажиллагааны зардал	(8,273)	(8,958)	(11,202)	25%
Татвар төлөхийн өмнөх ашиг	8,322	903	3,056	3x
Орлогын албан татвар	(1,146)	(166)	222	2x
Цэвэр ашиг	7,176	737	3,277	4x


САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(сая төгрөг)	2021	2022	2023	YOY
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	983	814	4,227	5x
Авлага	5,280	6,437	4,909	-24%
Бараа материал	25	28	31	9%
Урьдчилж төлсөн тооцоо	2,846	3,565	6,678	87%
Хөрөнгө оруулалт	23,610	24,181	24,732	2%
Үндсэн хөрөнгө	2,082	406	666	64%
Биет бус хөрөнгө	-	213	2,913	14x
НИЙТ ХӨРӨНГӨ	34,826	35,645	44,156	24%
Өр төлбөр	4,722	4,261	3,571	-16%
Нөөц сан	11,708	14,704	22,367	52%
Үүнээс: ОТХН	8,307	11,570	17,816	54%
Нөхөн төлбөрийн нөөц сан	3,401	3,135	4,551	45%
Нийт эздийн өмч	18,396	16,679	18,218	9%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ	34,826	35,645	44,156	24%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчид	12/31/2023		3/31/2024		Өөрчлөлт
		Тоо	%	Тоо	%	
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	11,377,911	45.5%	11,377,911	45.5%	-
2	Ардын тэтгэврийн данс ХХК	1,419,393	5.7%	1,432,641	5.7%	13,248
3	С. Оргил	1,164,822	4.7%	1,164,822	4.7%	-
4	Г. Бат-Эрдэнэ	1,164,822	4.7%	1,164,822	4.7%	-
5	Н. Мөнхнасан	1,140,742	4.6%	1,140,742	4.6%	-
6	Бодь Даатгал	866,965	3.5%	857,135	3.4%	(9,830)
7	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.3%	820,750	3.3%	-
8	Ард Кредит ББСБ ХХК	437,946	1.8%	438,389	1.8%	443
9	БиДиСек ҮЦК	314,294	1.3%	362,840	1.5%	48,546
10	Үндэсний хувьчлалын сан ХОС	342,534	1.4%	342,534	1.4%	-
11	А. Сүхдорж	203,994	0.8%	203,994	0.8%	-
12	Ч. Амарбаатар	166,000	0.7%	166,000	0.7%	-
13	Ард Секюритиз ҮЦК ХХК	224,437	0.9%	155,988	0.6%	(68,449)
14	Ард Бит ХХК	441,883	1.8%	116,053	0.5%	(325,830)
15	Апекс Капитал ҮЦК	95,366	0.4%	95,366	0.4%	-
16	Бусад	4,818,141	19.3%	5,160,013	20.6%	341,872
НИЙТ ДҮН		25,000,000	100.0%	25,000,000	100.0%	-
Хувьцаа эзэмшигчдийн тоо		9,763		9,732		(31)

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА




Хаалтын ханш	₮874.5
Дээд болон доод ханш:	₮681- ₮950
Нийт хувьцааны тоо:	25,000,000
Нийт арилжаалагдсан тоо:	1.9 сая
Нийт арилжааны дүн:	₮1.6 тэрбум
Зах зээлийн үнэлгээ:	₮21.9 тэрбум

EPS:	₮131
BVPS:	₮728.7
P/E - Үнэ/Ашиг:	6.7
P/B - Үнэ/Дансны үнэ:	1.2

ГРАНТ ТОРНТОН ИНТЕРНЭЙШНЛ

Бид дэлхийн 140 гаруй улс орны 62,000 гаруй мэргэжилтнүүдээс бүрдсэн баталгаажуулалт, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн зургаан том фирмийн нэг юм.



Бидний онцлог бол харилцагчдад үйлчлэх арга барил юм.



\$6.6 тэрбум
(2021 оны орлого)



62,000+
ажилтан



750+
оффис



140+
улс



- “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК нь 1999 онд аудит, НББ, зөвлөх үйлчилгээ эрхлэх чиглэлээр байгуулагдсан ба 2017 оны 11 сараас дэлхийн тэргүүлэх аудит, татвар, зөвлөх үйлчилгээний сүлжээ байгууллага болох “Грант Торнтон Интернейшнл”-ийн жинхэнэ гишүүн болсон.
- 2019 оноос “Улаанбаатар аудит корпораци” ХХК хуулийн этгээдийн оноосон нэрээ сольж “Грант Торнтон Аудит” ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байна.



Монголын аудитын салбарын Топ 6 компанийн нэг



5 Партнер



40+ Ажилтан

АУДИТЫН АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ



АУДИТЫН БАГ



Н. Эрдэнэцог
Гэрээт ажлын
партнер



Б. Дэлгэрмаа
Чанарын хяналтын
партнер



С. Уянга
Аудитын менежер




Г. Саруулсайхан
Багийн ахлагч



Ш. Долгорсүрэн
Багийн гишүүн



Б. Адьяацэрэн
Багийн гишүүн



Д. Энхтайван
Актуарч



“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тэвэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Ард Даатгал ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Ард Даатгал ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан дүрэм журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээж аудиторын үүрэг хариуцлагаа гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.



Аудитын тайлангийн онцлох асуудал

“Ард даатгал” ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай” 2020 оны 07 сарын 07-ны 132 дугаар тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан. Компани тайлант жилд удирдлагын шийдвэрээр өрийн үнэт цаасаарх ард койныг биет бус хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн бөгөөд холбогдох бодит үнэ цэнийн хэмжилтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан.



Зохистой харьцаа

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа хоёр дугаар түвшин болох хангалттай түвшинд (2022: 118.65%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.19-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг тодорхойлж, даатгагчийн төлбөрийн чадварын хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай гэж үзнэ” гэснийг хангасан байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 2

**НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ
ТУХАЙ**

CRYPTO WEEK

powered by  **ardcoin**

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

ARD | ДААТГАЛ
SINCE 1994

Шийдвэр гаргасан: ТУЗ


Тогтоол гаргасан огноо: 2024 оны 2 сарын
8-ны өдөр

Ногдол ашгийн хэмжээ: нэгж хувьцаанд
30 төгрөг, нийт 750 сая төгрөг

Олгох хугацаа: 2024 оны 4 сарын 30-ны
өдрийн дотор

The image shows the cover of a dividend distribution notice. At the top left, it features the 30th anniversary logo for ARD Daatgal, with '30 YEARS' and 'SINCE 1994'. At the top right, it displays the stock exchange listing 'MSE: ARD'. The main text in the center reads: 'АРД ДААТГАЛ ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ 750 САЯ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА'. At the bottom right, the slogan 'Хүчтэй. Хамтдаа.' is visible. A large red abstract graphic is on the left side of the page.

CRYPTO WEEK

powered by  ardcoin

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 3
2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН
ДҮГНЭЛТ

№07/24

*Компанийн 2023 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 4 сарын 15-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Грант Торнтон Аудит Ард Даатгал компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг **ХАНГАЛТТАЙ** гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, тайлангийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулахыг хурал зохион байгуулах комисс (Г.Цогбадрах)-т даалгасугай.

ДАРГА

О.ОДБАЯР

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 4

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



О. Одбаяр
ТУЗ-ийн дарга



Г. Уянга
Ердийн гишүүн



Б. Золбоо
Ердийн гишүүн



З. Ариун
Хараат бус гишүүн



Т. Билгээ
Хараат бус гишүүн



Г. Цогбадрах
Ердийн гишүүн



С. Оргил
Ердийн гишүүн



Ч. Ганзориг
Ердийн гишүүн



Б. Болорчимэг
Хараат бус гишүүн

5

Ээлжит
Ээлжит бус

2

Эчнээ

7

Хуралдсан тоо

25

Шийдвэрлэсэн
асуудлын тоо

ТУЗ-өөр шийдвэрлэсэн онцлох шийдвэрүүд:

- ✓ Хувь тэнцүүлсэн урамшуулал олгох тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2022 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ ТУЗ-ийн дарга болон хороодыг томилох тухай
- ✓ Бизнес төлөвлөгөө 2023-2026 батлах тухай
- ✓ 2024 оны компанийн төсөв, төлөвлөгөө батлах тухай
- ✓ Хөрөнгө оруулалт, Давхар даатгалын төлөвлөгөө батлах тухай
- ✓ Компанийн засаглалын сайжруулах, КЗК-ыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмуудыг шинээр болон шинэчлэн баталсан байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО



Б. Болорчимэг
Хорооны дарга



Ч. Ганзориг
Хорооны гишүүн



З. Ариун
Хорооны гишүүн



Т. Батцэнгэл
Хорооны нарийн бичиг

3

Ээлжит

12

Хэлэлцсэн
асуудлын тоо

Гол хэлэлцсэн асуудлууд

- ✓ ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ
- ✓ ТУЗ-ийн хороодыг дахин хуваарилах
- ✓ Компанийн засаглалын кодекс

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

САНХҮҮ, ЭРСДЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХОРОО



Б. Золбоо
Хорооны дарга



С. Оргил
Хорооны гишүүн



Т. Билгээ
Хорооны гишүүн



Г. Уянга
Хорооны гишүүн



З. Ариун
Хорооны гишүүн



Г. Баярбат
Хорооны нарийн бичиг

4

Ээлжит

24

Хэлэлцсэн
асуудлын тоо

Гол хэлэлцсэн асуудлууд

- ✓ Аудитлагдсан тайлан
- ✓ Улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангууд
- ✓ Гадаад төлбөр тооцооны тайлангууд
- ✓ Шүүхийн маргааны талаар
- ✓ Улирлын эрсдэлийн тайлан
- ✓ Компанийн төсөв, төлөвлөгөө
- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- ✓ Давхар даатгалын төлөвлөгөө

CRYPTO WEEK

powered by ardcoin

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

АУДИТЫН ХОРОО



З. Ариун
Хорооны дарга



Т. Билгээ
Хорооны гишүүн



Г. Уянга
Хорооны гишүүн



П. Бямбасүрэн
Хорооны нарийн бичиг

4

Ээлжит

16

Хэлэлцсэн
асуудлын тоо

Гол хэлэлцсэн асуудлууд

- ✓ Нөхөн төлбөрийн аудитын тайлан
- ✓ Хүний нөөцөд хийсэн аудитын тайлан
- ✓ Хөндлөнгийн аудитын дүгнэлт
- ✓ Давхар даатгалд хийсэн аудитын тайлан
- ✓ Борлуулалтын гэрээнд хийсэн аудитын тайлан
- ✓ Гэрээний бүртгэлд хийсэн аудитын тайлан
- ✓ Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- ✓ Орон нутгийн салбаруудад хийсэн аудитын тайлан

CRYPTO WEEK

powered by ardcoin

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

ТУЗ-ийн төсөв	Нэгж ₮	Нийт дүн ₮
ТУЗ-ийн гишүүдийн цалин	10,100,000 /сард/	121,200,000
Хурал зохион байгуулах		10,000,000
Эрүүл мэндийн даатгал		43,000,000
НИЙТ ЗАРДАЛ		174,200,000

ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал буюу Эрүүл мэндийн даатгалд хамруулах нөхцөл:

- ✓ ТУЗ-ийн гишүүдийн өөрийгөө үнэлэх үнэлгээ 30 хувь
- ✓ Гүйцэтгэх удирдлагын ТУЗ-ийн гишүүдийг үнэлэх үнэлгээний асуулга 30 хувь
- ✓ Хурлын ирц, хороодын хурлын ирц 40 хувиар тус тус тооцож 80 хувиас дээш үнэлгээ авсан ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал олгох эрх үүсдэг.

АСУУЛТ ХАРИУЛТ

САНАЛ ХУРААЛТ

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ТООЛЛОГЫН КОМИСС

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

“АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №2

2024 оны 4 сарын 23-ны өдөр

Санал хураалтын дүнгийн талаар

Компанийн нэр: Ард Даатгал ХК

Компанийн хаяг: Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 сарын 23-ны өдрийн 10:00 цагт Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сэнтрал Тауэрын 17 давхар, Ард Апп

Бүртгэлийн өдөр: 2024 оны 03 сарын 31-ний өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2024 оны 04 сарын 19-ний өдрийн 10:00 цаг хүртэл

Тооллогын комисс: Ө.Бямбагэрэл, Т.Батбаяр, Д.Бямбажаргал

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт ... ширхэг ... хувийн хувьцааг эзэмшигчид саналын хуудсаар зөвшөөрсөн санал өгч, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.19 дахь заалтад зааснаар Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг батлан шийдвэрлэв.

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс татгалзсан, түдгэлзсэн болон хүчингүй саналын хуудас байхгүй болно.

ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛАХ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 23-ны өдөр
ХОТ

Дугаар 01/24

Улаанбаатар

2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2024 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б. ЗОЛБОО

ХҮЧТЭЙ. ХАМТДАА.